~~126~~
115

МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ҮНДЭСНИЙ ПАРКЫН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2015 оны 02 сарын 25 өдөр Дугаар 034 Улаанбаатар хот

ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20-р зүйлийн 20.1.10, Мэдээллийн технологийн үндэсний паркын дүрмийн 8-р зүйлийн 8.5.8, Хөдөлмөрийн дотоод журмын 7-р зүйлийн 7.1.1-р заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

Нэг. Мэдээллийн технологийн үндэсний паркын "Технологи дамжуулах журам"-ыг хавсралт ёсоор баталсугай.

Хоёр. Журмын хэрэгжилтийг ханган ажиллах төлөвлөгөө гарган ажиллахыг Инноваци технологийн төв /Д.Батхуяг/-д даалгасугай.

Гурав. Энэхүү тушаал батлагдан гарсантай холбогдуулж байгууллагын нийт ажилтан, албан хаагчдад танилцуулж, хяналт тавьж ажиллахыг Захиргаа, хүний нөөцийн газар/Ц.Эрдэнэлхам/-т даалгасугай.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ Б.МЯГМАРНАРАН

ТЕХНОЛОГИЙН УЛААНБААТАР ХОТ МЭДЭЭЛЛИЙН ҮНДЭСНИЙ ПАРК ТТГ5782 ☎ 2718022 ТӨААТҮГ

ПАРКЫН ТЕХНОЛОГИ
ДАМЖУУЛАХ ЖУРАМ

(ТӨСЛИЙН ЭХ)

2015 оны 2 сар

МТҮП-ын ДОТООД ХЭРЭГЛЭЭНД ЗОРИУЛАВ.

АГУУЛГА

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ 4

1 ДҮГЭЭР ЗҮЙЛ. ЖУРМЫН ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ 4
2 ДУГААР ЗҮЙЛ. ЖУРМЫН НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ 4
3 ДУГААР ЗҮЙЛ. ОЮУНЫ ӨМЧ 6

ХОЁРДУГААР БҮЛЭГ. БАРИМТЛАХ БОДЛОГО 6

4 ДҮГЭЭР ЗҮЙЛ. ПАТЕНТ БА ЗОХИОГЧИЙН ЭРХ 6
5 ДУГААР ЗҮЙЛ. ЗАХИАЛГАТ СУДАЛГАА БА БУСАД ГЭРЭЭТ АЖИЛ 7
6 ДУГААР ЗҮЙЛ. ПАРКЫН ӨМЧ ХӨРӨНГИЙГ МЭДЭГДЭХҮЙЦ ХЭМЖЭЭНД АШИГЛАХ 7
7 ДУГААР ЗҮЙЛ. ЗОХИОГЧИЙН ХУВИЙН БҮТЭЭЛ 8
8 ДУГААР ЗҮЙЛ. БАРААНЫ ТЭМДЭГ 8
9 ДҮГЭЭР ЗҮЙЛ. КОМПЬЮТЕРИЙН ПРОГРАМ ХАНГАМЖИЙГ ХЭРЭГЛЭХ 9
10 ДУГААР ЗҮЙЛ. ПАРКЫН БҮТЭЭГЧ/ЗОХИОГЧ НАРТ ЭРХ ШИЛЖҮҮЛЭХ 9

ГУРАВДУГААР БҮЛЭГ. ТЕХНОЛОГИЙГ ҮНЭЛЭХ, ХАМГААЛАХ БА ДАМЖУУЛАХ 9

11 ДҮГЭЭР ЗҮЙЛ. ЧИГ ҮҮРЭГ 9
12 ДУГААР ЗҮЙЛ. ТЕХНОЛОГИ ЗАДЛАХ 10
13 ДУГААР ЗҮЙЛ. ПАТЕНТ: ХАМГААЛАЛ 10
14 ДҮГЭЭР ЗҮЙЛ. ЗОХИОГЧИЙН ЭРХ: НОТЛОХ БА БҮРТГЭХ 10
15 ДУГААР ЗҮЙЛ. БАРААНЫ ТЭМДЭГ: НОТЛОХ БА БҮРТГЭХ 11
16 ДУГААР ЗҮЙЛ. КОМПЬЮТЕРИЙН ПРОГРАМ ХАНГАМЖААС БУСАД ЗОХИОГЧИЙН ЭРХЭЭР ХАМГААЛАГДАХ БҮТЭЭЛИЙГ НЭЭЛТТЭЙ ТҮГЭЭХ 11
17 ДУГААР ЗҮЙЛ. КОМПЬЮТЕРИЙН ПРОГРАМ ХАНГАМЖИЙГ СУДАЛГААНЫ ЗОРИЛГООР БОЛОН НЭЭЛТТЭЙ ЭХ СУРВАЛЖААР ТҮГЭЭХ 11

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ТЕХНОЛОГИЙН АРИЛЖААНЫ ХӨГЖҮҮЛЭЛТ 12

18 ДУГААР ЗҮЙЛ. АРИЛЖААНЫ ҮЗЭЛ БАРИМТЛАЛ 12
19 ДҮГЭЭР ЗҮЙЛ. ЗАХ ЗЭЭЛД НЭВТРҮҮЛЭХ - АРИЛЖААЛАХ 12
20 ДУГААР ЗҮЙЛ. ПАТЕНТЫГ АРИЛЖААЛАХ 13
21 ДҮГЭЭР ЗҮЙЛ. ЗОХИОГЧИЙН ЭРХТЭЙ БҮТЭЭЛИЙГ АРИЛЖААЛАХ 13
22 ДУГААР ЗҮЙЛ. БАРААНЫ ТЭМДГИЙГ АРИЛЖААЛАХ 14
23 ДУГААР ЗҮЙЛ. ПАРК БҮТЭЭГЧ/ЗОХИОГЧИД НЬ ЛИЦЕНЗ ОЛГОХ 14
24 ДҮГЭЭР ЗҮЙЛ. РОЯЛТИ АШИГ ХУВААРИЛАХ 14
25 ДУГААР ЗҮЙЛ. РОЯЛТИ – ОНЦГОЙ ТОХИОЛДОЛД ХУВААРИЛАХ 16
26 ДУГААР ЗҮЙЛ. АШИГ СОНИРХОЛЫН ЗӨРЧИЛДӨӨНӨӨС СЭРГИЙЛЭХ ТУХАЙ 16

ТАВДУГААР БҮЛЭГ. МЭРГЭЖИЛТЭН БА ГЭРЭЭТ АЖИЛТНЫ ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА 17

27 ДУГААР ЗҮЙЛ. ҮҮРЭГ ХАРИУЦЛАГЫН ТУХАЙ 17

28 ДУГААР ЗҮЙЛ. ХУВЬ ХҮНИЙ ШИНЭ БҮТЭЭЛ БА ҮНЭТ МЭДЭЭЛЛИЙН НУУЦЫН ГЭРЭЭ 18

ЗУРГААДУГААР БҮЛЭГ. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ 18

29 ДҮГЭЭР ЗҮЙЛ. ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ 18

30 ДУГААР ЗҮЙЛ. ИННОВАЦИ, ТЕХНОЛОГИЙН ТӨВ 18

31 ДҮГЭЭР ЗҮЙЛ. БУСАД 19

ХАВСРАЛТ А- МАЯГТ, ГЭРЭЭНИЙ ЗАГВАРУУД 19

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл. Журмын зорилт, хамрах хүрээ

1.1 Энэхүү журмын зорилт нь Мэдээллийн технологийн үндэсний парк /цаашид "Парк" гэх/ -ын дангаар болон хамтран хэрэгжүүлсэн болон хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрүүдийн үр дүнд шинээр бүтээсэн, сайжруулан хөгжүүлсэн технологийг эзэмших эрх эдлэх, түүнийг зах зээлд нэвтрүүлэх, түүнээс орох ашгийг хуваарилахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2 Мөн энэхүү журмаар Паркд бий болсон технологиос гадна судалгааны байгууллага, аж ахуйн нэгж, хувь хүн эдийн засгийн эрхийг нь эзэмшдэг оюуны өмч, технологийг дамжуулах, эдийн засгийн эргэлтэд оруулах үйл ажиллагааг зохицуулна.

1.3 Паркын технологи дамжуулах журам /цаашид "Журам" гэх/ нь Монгол Улсын хууль тогтоомж, Засгийн Газрын шийдвэр, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, Паркын Оюуны өмчийн бодлого зэргийг дагаж мөрдөнө.

2 дугаар зүйл. Журмын нэр томьёоны тодорхойлолт

2.1 Энэ журамд хэрэглэсэн дараах нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно:

2.1.1 "Технологи" гэж шинэ бүтээл, ашигтай загвар, нээлт, компьютерын програм, түүнчлэн төрөл бүрийн хэлбэрээр бичигдсэн мэдээлэл, бичмэл материалыг оруулан өргөн хүрээгээр ойлгоно. Мөн "технологи" гэсэн ойлголтод шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагааны үр дүнд бий болж, эдийн засаг, нийгмийн үр ашиг авчрах шинэ болон шинэчлэн сайжруулсан бүтээгдэхүүн, үйлчилгээ, технологийн шийдлийг илэрхийлэх инновацийг бас хамруулан ойлгоно.

2.1.2 "Оюуны өмч" гэж Монгол Улсын Патентын тухай хууль, Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хууль, Барааны тэмдэг газар зүйн заалтын тухай хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээний дагуу хамгаалагдах оюуны үнэт зүйлсийг ойлгоно.

2.1.3 "Мэргэжилтэн" гэж Паркын дүрэмд ажилтанг;

2.1.4 "Гэрээт ажилтан" гэж Паркын хэрэгжүүлж байгаа төсөл хөтөлбөрт гадны байгууллагаас хамрагдан оролцож байгаа этгээдийг;

2.1.5 "Бойжигч компани" гэж Паркын бизнес инкубаторт бойжиж байгаа аж ахуйн нэгжийг;

2.1.6 "Гарааны компани" гэж Инновацийн тухай хуульд заасан компанийг;

2.1.7 "Паркын нэгж" гэж Паркын дүрэмд заасан харьяаллын нэгжийг;

2.1.8 "Судалгааны байгууллага" гэж Шинжлэх ухаан, технологийн хуульд заасан эрдэм шинжилгээний байгууллагуудыг;

2.1.9 "Патент" гэж Монгол Улсын Патентын тухай хуулийн дагуу тухайн шийдэл нь шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар болохыг тодорхойлж, зохиогч эсвэл түүнээс эрхийг нь шилжүүлэн авсан этгээд, тодорхой хугацаанд түүнийг

эзэмших онцгой эрхтэй болохыг хүлээн зөвшөөрч, Төрийн эрх бүхий байгууллагаас олгож байгаа баримт бичгийг;

2.1.10 "Зохиогчийн эрх" гэж Монгол Улсын Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуульд заасан зохиогчийн оюуны бүтээлч үйл ажиллагааны үр дүнд бий болсон шинжлэх ухаан, утга зохиол, урлагийн бүтээлийн эрх бөгөөд, шууд эсвэл машин, тоног төхөөрөмжийн тусламжтайгаар харилцаж, мэдэрч болдог бичмэл, аман, зурмал болон бусад биет хэлбэрээр бүтээсэн бүтээлүүдийн эрхийг хамгаална

2.1.11 "Бараа, үйлчилгээний тэмдэг (цаашид "Барааны тэмдэг" гэх)" гэж Барааны тэмдэг газар зүйн заалтын тухай хуульд заасан иргэн, хуулийн этгээд өөрийн бараа, үйлчилгээг бусад этгээдийн бараа үйлчилгээнээс ялгах зорилгоор хэрэглэх ялгагдах чадвартай илэрхийллийг буюу бүтээсэн үг, үсэг, тоо, нэр, тэмдэг, гурван хэмжээст дүрс, өнгө, дуу авиа, үнэр, эсвэл биет зүйлс, тэдгээрийн хослолыг хэлнэ.

2.1.12 "Газар зүйн заалт" гэж Барааны тэмдэг газар зүйн заалтын тухай хуульд заасан тухайн газар нутгийн байгаль, цаг уурын нөхцөл, эсхүл тухайн газар нутгийн хүмүүсийн дадал заншил зэрэг хүчин зүйлээр тодорхойлогдсон чанар, нэр хүнд, бусад онцлог шинж чанар бүхий бараа, бүтээгдэхүүнийг үйлдвэрлэсэн улс, бүс, газар нутгийн газар зүйн тодорхойлолтыг;

2.1.13 "Мэдэгдэхүйц хэмжээ" гэж энэ журмын 6 дугаар зүйлд заасан хэм хэмжээг;

2.1.14 "Өмч хөрөнгө" гэж Паркын дэд бүтэц, үл хөдлөх хөрөнгө, лабораторийн нарийн багаж, тоног төхөөрөмж, материаллаг бааз, хүний нөөц зэргийг;

2.1.15 "Нууц" гэж Монгол Улсын Өрсөлдөөний тухай, Байгууллагын нууцын тухай, Хувь хүний нууцын тухай хуулиудад тодорхойлогдсон нууцын зэрэгтэй мэдээлэл, задруулбал хууль ёсны ашиг сонирхолд нь хор уршиг учруулж болох нууц мэдээ, технологийн шийдэл, төсөл, судалгаа-шинжилгээний баримт бичиг, шаардлагатай техник, тоног төхөөрөмжийг;

2.1.16 "Технологи задлах" (technology disclosure) гэж нууцын зэрэгтэй байсан технологийн тухай мэдээллийг технологи дамжуулал хариуцсан нэгжид мэдэгдэн ил болгож, холбогдох хууль тогтоомжийн дагуу оюуны өмчийн хамгаалалт хийх ажиллагааг эхлэх үйл явцыг;

2.1.17 "Бүтээгч" гэж Патентын тухай хуулийн 3.1.6-д заасан этгээдийг;

2.1.18 "Зохиогч" гэж Зохиогч эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуулийн 3.1.1-д заасан этгээдийг;

2.1.19 "Тохиолдол" (Case) гэж технологи задлах эсвэл технологи дамжуулах нэг удаагийн явцаас гарч ирэх патент, програм хангамж зэргийг ойлгоно;

2.1.20 "Роялти орлого" (Royalty Income) гэж оюуны өмчийг зах зээлд нэвтрүүлснээс гэрээний дагуу лицензийн төлбөр, эсвэл эрх шилжүүлсний төлбөр хэлбэрээр олох орлого;

2.1.21 "Шууд зардал" (out-of-pocket cost) гэж оюуны өмчийг патентаар бүртгүүлэх, хамгаалах, хүчин төгөлдөр хугацааг хадгалах, мөн технологи дамжуулах, патентын маркетингийн зардал зэрэгт зарцуулах зарлагыг;

2.1.22 "Роялти ашиг" гэж Роялти орлогоос Шууд зардлыг хассаны дараа үлдэх ашгийг;

2.1.23 "Бүтээгчийн хувь" гэж зохион бүтээгч/зохиогчид энэ журмын дагуу хуваарилах роялти ашгийн хувь хэмжээг;

2.2 Паркын технологи дамжуулах журамд Монгол Улсын хууль тогтоомжид хэрэглэж хэвшсэн хэлбэрээр нь нэр томьёог ашиглах зарчим баримтална.

3 дугаар зүйл. Оюуны өмч

3.1 Энэхүү журамд цаашид технологийг эзэмших эрх эдлэх, эдийн засгийн эрх эдлэх, захиран зарцуулахтай холбогдсон үндсэн эрхийг "оюуны өмчийн эрх" гэнэ. Оюуны өмчийн эрх нь шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварт патент; ашигтай загварт ашигтай загварын гэрчилгээ; барааны тэмдэгт гэрчилгээ; газар зүйн заалтад гэрчилгээ зэргийг Монгол Улсын холбогдох хуулийн дагуу олгосноос эхлэн үүснэ.

3.2 Технологийг дамжуулах болон арилжаалах үйл явц нь патент, зохиогчийн эрх зэрэг оюуны өмчийн эрхийг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу шилжүүлэх, эсвэл лицензээр ашиглуулах хэлбэрээр хэрэгжинэ.

3.3 Энэхүү журамд цаашид шинэ бүтээлийг (патент) голлон жишээ болгон авч үзэх бөгөөд тусгайлан заагаагүй бол ашигтай загварыг бас хамруулан ойлгоно.

3.4 Оюуны өмчийн эрхийн талаар дэлгэрэнгүй мэдээллийг Паркын Инноваци, технологийн төв / цаашид "ИТТ" гэх/-өөс авна.

ХОЁРДУГААР БҮЛЭГ. БАРИМТЛАХ БОДЛОГО

4 дүгээр зүйл. Патент ба зохиогчийн эрх

4.1 Энэ журмыг хэрэгжүүлэхдээ 1.3 дахь заалтыг баримтлан оюуны өмч хэлбэрээр хамгаалах технологийг эзэмших, арилжаалах, түүнээс орох ашгийг хуваарилахтай холбогдсон бүх харилцааг зохицуулна.

4.2 Паркын дангаар буюу хамтран хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрүүдэд оролцож буй этгээдийн бий болгосон, хөгжүүлсэн шинэ бүтээл, ашигтай загвар, бүтээгдэхүүний загвар болон компьютерын програм хангамж зэрэг зохиогчийн эрхээр хамгаалагдах бүтээлийн эрхийг дараах байдлаар эзэмшинэ. Үүнд:

4.2.1 Паркын санхүүжилт, өмч хөрөнгийг (facility) ашиглан бүтээсэн/хөгжүүлсэн патент, ашигтай загвар, бүтээгдэхүүний загвар, програм хангамж болон бусад зохиогчийн эрхээр хамгаалагдах бүтээл, судалгааны биет хөрөнгө, барааны тэмдгийн эрхийг дараах нөхцөлүүдэд Парк эзэмшинэ:

4.2.1.1 Иргэн, хуулийн этгээдтэй Паркын байгуулсан гэрээт ажлын хүрээнд оюуны өмчийг бүтээсэн бол;

4.2.1.2 Энэ журмын 6 дугаар зүйлд тодорхойлсны дагуу Паркын санхүүжилт, өмч хөрөнгийг (facility) мэдэгдэхүйц хэмжээгээр (significant use) ашиглан оюуны өмчийг бүтээсэн бол холбогдох гэрээний дагуу;

4.2.1.3 Монгол Улсын Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлд заасны дагуу албан үүргийн дагуу (work for hire) бүтээсэн бол, эсвэл Парктай бичгээр хийсэн гэрээндээ тухайн

бүтээлийн эдийн бус баялгийн эрхээс бусад зохиогчийн эрхээ Парк-д шилжүүлэхийг зөвшөөрсөн бол;

4.2.2 Энэ журмын 4.2.1-д заасан ямар нэг хэлбэрээр Парк эзэмших эрх үүсэхгүй нь тодорхой болсон нөхцөлд бүтээгч/зохиогч нь бүтээлийн патент, зохиогчийн эрхийг эзэмших эрхтэй.

4.2.3 Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуулийн дагуу бичмэл гэрээнд өөрөөр заагаагүй бол орон тооны бус буюу гэрээт ажилтны гүйцэтгэсэн ажлын үр дүнг гүйцэтгэгч нь эзэмшинэ.

4.2.4 Паркын эзэмших эрхийг Парк эзэмшихгүй болохоо илэрхийлсэн тохиолдолд бүтээгч/зохиогч нь бүтээлийн патент, зохиогчийн эрхийг эзэмших эрхтэй.

5 дугаар зүйл. Захиалгат судалгаа ба бусад гэрээт ажил

5.1 Засгийн Газрын захиалгат судалгааны ажлын явцад анх санаачлан гаргасан, эсвэл бодит нөхцөлд буулган бүтээсэн шинэ бүтээлд Паркын эдлэх эрх Засгийн Газартай байгуулсан гэрээгээр тодорхойлогдоно. Засгийн Газар онцгой эрхгүй лиценз (non-exclusive license) эзэмших бөгөөд Парк-д түүний эзэмших эрх хадгалагдах ба лиценз олгох болон бусад аргаар шинэ бүтээлийг бодит хэрэглээнд нэвтрүүлэх үүргийг Парк хүлээнэ.

5.2 Үйлдвэр, компанийн захиалгат судалгааны ажлын хүрээнд бүтээсэн оюуны өмчийн эзэмших эрхийг гэрээнд нарийвчлан заагаагүй бол Парк эдэлж болох бөгөөд тухайн захиалагч байгууллага давуу эрхтэйгээр лицензээр эзэмшиж болно.

5.3 Зохиогчийн эрх авах шалгуур хангасан бүтээлийг эзэмших онцгой эрхийг Засгийн Газартай байгуулсан гэрээний дагуу зохицуулна. Засгийн Газар зохиогчийн эрхийн шимтгэл (royalty-free)-гүй лиценз эзэмшиж болох бөгөөд энэ тохиолдолд зохиогчийн эрх нь Парк-д үлдэнэ.

5.4 Бүтээлийг бусад байгууллагуудын захиалсан гэрээт судалгааны ажлын хүрээнд бүтээсэн бол зохиогч нь тухайн бүтээлийг хэвлүүлэх, эсвэл түүнтэй төстэй хэлбэрээр нийтэд дэлгэрүүлэхдээ захиалагч талтай байгуулсан гэрээнд энэ талаар мэдээлэх үүрэг хүлээсэн эсэхийг нягтлах үүрэгтэй.

5.5 Паркын мэргэжилтэн, гэрээт ажилтан нь хамтын ажиллагааны гэрээний заалтуудыг хэрхэн ойлгох талаар мэдээлэл, туслалцаа авах тохиолдолд, ИТТ-д хандана.

5.6 Хамтарсан төсөл хөтөлбөр хэрэгжүүлэхэд шаардлагатай тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу нууцлалын гэрээ байгуулна.

6 дугаар зүйл. Паркын өмч хөрөнгийг мэдэгдэхүйц хэмжээнд ашиглах

6.1 Паркын мэргэжилтэн, гэрээт ажилтан, Паркын хөтөлбөрт оролцож буй бусад этгээдүүд Паркын санхүүжилт, өмч хөрөнгийг мэдэгдэхүйц хэмжээгээр ашиглан шинэ бүтээл, ашигтай загвар, бүтээгдэхүүний загвар, компьютерын програм хангамж, эсвэл зохиогчийн эрхийн шалгуур хангасан бусад бүтээл бүтээсэн бол Парк нь патент, зохиогчийн эрх, эсвэл бусад биет бүтээл, эсвэл оюуны өмчийн эрхийг эзэмшинэ.

6.2 Хэрэв бүтээл нь гуравдагч этгээдээс захиалсан, эсвэл бусад гэрээт судалгааны ажилд хамаарахгүй бол Паркын санхүүжилт, өмч хөрөнгийг мэдэгдэхүйц хэмжээгээр ашигласан эсэхийг бүтээгч/зохиогчийн харьяалах нэгжийн удирдлага хянаж саналаа Хавсралт А1 маягтын дагуу илэрхийлж, ИТТ-д хүргүүлнэ.

6.3 Паркын албан өрөө, номын сан, засварын цех, харилцаа холбооны хэрэгсэл болон энгийн компьютер зэргийг ашигласан тохиолдолд Паркын өмч хөрөнгийг (facility) мэдэгдэхүйц хэмжээгээр ашигласанд тооцохгүй.

6.4 Паркаас сурах бичиг, сургалттай холбоотой номыг зохиоход зориулан төсөв зарцуулаагүй тохиолдолд сургалтын материал болгон бичсэн сурах бичиг, номыг "мэдэгдэхүйц хэмжээний хэрэглээ" ангиллаас хасч тооцно

6.5 Шинэ бүтээл, компьютерын програм хангамж, эсвэл зохиогчийн эрхийн шалгуур хангасан бусад бүтээлийг доорх нөхцөлд бүтээсэн/хөгжүүлсэн бол Паркын санхүүжилт, өмч хөрөнгийг ашиглан бүтээсэнд тооцохгүй. Үүнд:

6.5.1 Зөвхөн маш бага хэмжээний санхүүжилт ашигласан бол;

6.5.2 Зөвхөн маш бага хугацаанд чухал ач холбогдолтой тоног төхөөрөмжийг ашигласныг харьяалах удирдлага нь тодорхойлсон бол;

6.6 Бүтээлийг бүтээгч/зохиогчийн хувийн, ажлын бус цагт бүтээсэн бол;

7 дугаар зүйл. Зохиогчийн хувийн бүтээл

7.1 Ном, сурах бичиг, өгүүлэл болон бусад шинжлэх ухааны хэвлэлүүд түүнчлэн олон нийтэд зориулсан утга зохиолын ном, яруу найраг, хөгжмийн зохиол ба бусад урлагийн бүтээл зэргийг дараах нөхцөлд Парк зохиогчийн эрхийг эдлэхгүй. Үүнд:

7.1.1 Мэргэжилтэн нь өөрөө бие даан хувиараа бүтээсэн бол;

7.1.2 Паркын санхүүжилт, өмч хөрөнгөөс энэ журмын 6 дугаар зүйлд зааснаар "мэдэгдэхүйц хэмжээнд" ашиглаагүй бол;

7.1.3 Аливаа захиалгат болон бусад гэрээт төсөл, хөтөлбөрийн хүрээнд хамаарахгүй бол;

7.2 Паркын мэргэжилтэн албан үүрэгтээ хамааралгүй бүтээсэн оюуны өмчийн зохиогчийн эрхээ эзэмших хүсэлт гаргасан бол Парк нь хүсэлтийг санхүүжүүлэгч тал ба харьяалах нэгжийн удирдлага зөвшөөрсний дагуу хүлээн авч эрхийг нь зохиогчид шилжүүлнэ. Энэ тохиолдолд зохиогч нь Хавсралт А1 маягтыг бөглөн ИТТ-д өгсөн байна.

8 дугаар зүйл. Барааны тэмдэг

8.1 Парк-д бүтээсэн бүтээгдэхүүн ба үйлчилгээнд хэрэглэх барааны ба үйлчилгээний тэмдэг нь Паркын өмч байна.

8.2 Паркын нэр, бэлэг тэмдэг, уриа үг зэргийг ашиглах харилцааг тусгай журмаар зохицуулна.

9 дүгээр зүйл. Компьютерийн програм хангамжийг хэрэглэх

9.1 Парк-д хэрэглэж байгаа компьютерын програм хангамж ба мэдээллийн сангийн эрхийг хэрэглэгч, эсвэл гуравдагч этгээд эзэмшиж байгаа бол, эсвэл зохиогчийн эрх болон бусад хууль тогтоомжоор хамгаалсан бол, эсвэл лицензийн болон бусад гэрээгээр зохицуулсан бол Паркын хэрэглэгчид тухайн програм хангамж, мэдээллийн сангийн эрхийг эзэмшигчийн тогтоосон хязгаарлалтуудыг дагаж мөрдөх ёстой.

9.2 Компьютерын програм хангамж, мэдээллийн сангийн эрхийг эзэмшигч нь тогтоосон хязгаарлалтуудынхаа нөхцөлүүдийг Парк-д мэдээлэх үүрэгтэй.

10 дугаар зүйл. Паркын бүтээгч/зохиогч нарт эрх шилжүүлэх

10.1 Бүтээгч/зохиогч нь бүтээлээ эзэмших эрх хүссэн нь үндэслэлтэй тохиолдолд Парк бүтээлийн оюуны өмчлөлийн асуудалд оролцохгүй байж (stand aside) болно. Энэ тохиолдолд хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэсэн нь дараах нөхцөлийг хангасан байна. Үүнд:

10.1.1 Технологийг нийтэд дэлгэрүүлэх явцыг эрчимжүүлэх;

10.1.2 Гуравдагч этгээдийн өмнө хүлээсэн үүргээ зөрчихгүй байх;

10.1.3 Аливаа сонирхлын зөрчилдөөнд оролцохгүй байх;

10.2 Өмчлөлийн асуудалд оролцохгүй тохиолдолд Парк нь технологийн талаар гэрээнд заасан эрхээсээ татгалзаж, бүтээгч/зохиогч нарт оюуны өмчөө эзэмших эрхийг нь нээж өгнө. Бүтээгч/зохиогчид Хавсралт А1 маягтыг бөглөн ИТТ-д хүргүүлэн өгч Паркыг эрхээсээ татгалзахыг хүссэн хүсэлт гаргана.

10.3 Төсвөөс санхүүжсэн төсөл, хөтөлбөрийн үр дүнд бий болсон тохиолдолд Парк нь эрхээсээ татгалзах нөхцөлд бүтээгч/зохиогч уг бүтээлийн эрхийг олгохыг хүссэн хүсэлтээ Засгийн Газарт гаргаж болно.

10.4 Аж ахуйн нэгжээс санхүүжүүлж лицензийг нь эзэмших эрхтэй судалгааны ажлын үр дүнг бүтээгч/зохиогч нь эзэмшихийг хүсвэл захиалагч буюу санхүүжүүлэгч талын зөвшөөрлийг авсны дараа Парк эрхийг шилжүүлнэ.

ГУРАВДУГААР БҮЛЭГ. ТЕХНОЛОГИЙГ ҮНЭЛЭХ, ХАМГААЛАХ БА ДАМЖУУЛАХ

11 дүгээр зүйл. Чиг үүрэг

11.1 Паркын технологийг нийгмийн тусын тулд дамжуулах чиг үүргийг Инноваци, технологийн төв (ИТТ) хэрэгжүүлнэ. ИТТ энэ журмын 3-р бүлэгт заасны дагуу технологийг үнэлж, оюуны өмчийн хамгаалалт хийж, технологийг арилжааны зорилгоор хөгжүүлэхэд туслалцаа үзүүлэх ба зэх зээлд нэвтрүүлэх боломжтой технологийг сонгон авч 4-р бүлэгт заасан лицензийн гэрээг байгуулах болон арилжих үүрэгтэй.

11.2 Компьютерын програм хангамж, мэдээллийн сангийн эрхийг эзэмшигч нь тогтоосон хязгаарлалтуудынхаа нөхцөлүүдийг Парк-д мэдээлэх үүрэгтэй.

12 дугаар зүйл. Технологи задлах

12.1 Технологи дамжуулах үйл явц нь Паркын Технологи задлах маягтыг (Хавсралт А2 маягтыг үзнэ үү) ИТТ-д илгээснээр эхэлнэ. Технологи задлах маягтын хамт "Паркын технологийн оюуны өмчлөлийг шилжүүлэн авах хүсэлт" (Хавсралт А1 маягт)-ийг хүлээн авснаас бусад тохиолдолд ИТТ нь тухайн технологид патент (эсвэл оюуны өмчийн бусад хэлбэрээр хамгаалах) авах болон зах зээлд нэвтрүүлэх боломжийг судлах үйл ажиллагааг эхлүүлнэ.

12.2 ТДТ нь Технологи задлах маягтыг хүлээн авмагц, хувийн дугаар олгож тухайн технологийг үнэлэх үйл ажиллагааг эхлүүлнэ.

13 дугаар зүйл. Патент: Хамгаалал

13.1 Төсөл санхүүжүүлэгч буюу захиалагч тал хүсэлт гаргаагүй тохиолдолд эдийн засгийн тодорхой үр ашиггүй оюуны бүтээлийг Парк нь патент болгон хамгаалах ажлыг хийхгүй.

13.2 Парк нь лицензийн гэрээгээр зах зээлд нэвтрүүлэх боломжтой эсвэл захиалгат ажил, хамтын ажиллагааны гэрээнд заасан тохиолдолд шинэ бүтээлийг патент болгон эрхийг нь хамгаална. Шинэ бүтээлийг патентын эрхээр хамгаалах үйл явцыг "ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ТЕХНОЛОГИЙН АРИЛЖААНЫ ХӨГЖҮҮЛЭЛТ"-т зааснаар зохицуулна.

13.3 Патент хүссэн мэдүүлэг гаргахаас өмнө тухайн шинэ бүтээлийн талаар аман ба бичгээр олон нийтэд дэлгэх шаардлага гарсан тохиолдолд ИТТ-тэй зөвшилцөнө.

13.4 Шинжлэх ухааны тодорхой чиглэлээр эрдэм шинжилгээний өгүүлэл хэвлүүлэх тохиолдолд патентын эрхийн талаар ИТТ-тэй урьдчилан зөвшилцөж, ИТТ зохих шийдвэр гаргасны дараа өгүүллийг хэвлүүлнэ.

14 дүгээр зүйл. Зохиогчийн эрх: Нотлох ба бүртгэх

14.1 Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхээр хамгаалах бүтээл, жишээлбэл ном, өгүүлэл, хэвлэл, програм хангамжийн код зэрэг бүтээлийн зохиогчийг нь тодорхойлж, бүрэн бүтэн байдлыг нь баталгаажуулна.

14.2 Бүтээлийг ашиглах онцгой эрх эзэмшигч нь Парк байх тохиолдолд эрхээ нийтэд таниулах зорилгоор дараах таних тэмдгийг байрлуулна.

"Copyright © [Year] NATIONAL INFORMATION TECHNOLOGY PARK, MONGOLIA. All rights reserved."

"Зохиогчийн эрхтэй © [Он] МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ҮНДЭСНИЙ ПАРК. Бүх эрх хуулиар хамгаалагдсан."

14.3 Таних тэмдэг дэх он нь бүтээлийн анх нийтлэгдсэн он байна. Дээрхээс өөр таних тэмдгийг Паркын эзэмшлийн бүтээлд хэрэглэхийг хориглоно.

15 дугаар зүйл. Барааны тэмдэг: Нотлох ба бүртгэх

15.1 Барааны тэмдгийг Паркын тодорхой үйл ажиллагаа, арга хэмжээ, компьютерын програм хангамж зэрэг технологийн дэвшилтэт бүтээгдэхүүнтэй холбогдох нэр, билэг тэмдгийг бусдаас ялган хамгаалахад хэрэглэнэ.

15.2 Оюуны өмчийн газарт бүртгүүлэхээс өмнө барааны тэмдгийн ард ТМ, үйлчилгээний тэмдгийн ард SM тэмдгийг тус тус байрлуулна. Барааны тэмдгийг Оюуны өмчийн газарт бүртгүүлсний дараа "®" тэмдгийг хэрэглэнэ.

15.3 Паркын эзэмшдэг барааны тэмдгийг бүртгүүлэх, хэрэглэх, захиран зарцуулахтай холбоотой асуудлыг ИТТ хариуцна.

16 дугаар зүйл. Компьютерын програм хангамжаас бусад зохиогчийн эрхээр хамгаалагдах бүтээлийг нээлттэй түгээх

16.1 Гуравдагч этгээдийн өмнө гэрээгээр хүлээсэн үүрэгтэй зөрчилдөхгүй бол Паркын мэргэжилтэн, гэрээт ажилтан – зохиогчид харьяалах нэгжийн удирдлага, бүх хамтран зохиогчидтойгоо тохиролцсоны үндсэн дээр бүтээлийг ашиглалтын төлбөргүй лицензийн гэрээгээр нээлттэй түгээх, шууд олон нийтийн хүртээл болгож болно.

16.2 Зохиогч нь програм хангамж болон зохиогчийн эрхээр хамгаалж болохуйц бусад бүтээл нь өргөн хүрээтэй хэрэглээ бий болгох боломжтой, тухайлбал компьютерын үйлдлийн систем зэрэг шинэ стандарт тогтоохоор байвал тухайн бүтээлээ шууд үнэ төлбөргүй олны хүртээл болгохоор хүсэлтээ ИТТ-д гаргаж болно.

16.3 Үнэ төлбөргүй олны хүртээл болгох хүсэлтийг ИТТ шийдвэрлэхдээ уг бүтээл нь хэр их дэвшил авчрах, хэрэглэхэд төвөгтэй байдал үүсгэх эсэх, олон нийт үр ашигтай хэрэглэх боломжтой эсэх, чанараа хадгалж чадах эсэх, мөн зохиогч нь үнэгүй олны хүртээл болгох замыг сонгосон шалтгаан зэргийг нягталж үзнэ.

17 дугаар зүйл. Компьютерын програм хангамжийг судалгааны зорилгоор болон нээлттэй эх сурвалжаар түгээх

17.1 Компьютерын програм хангамж нь зах зээлийн өндөр үнэ цэнэтэй бол, эсвэл Төслийн Удирдагч шилжүүлсний дараах хэрэглээг хянахыг хүсвэл, эсвэл бүтээлийг захиалгат судалгааны ажлын хүрээнд бүтээсэн бол Паркын эзэмшлийн компьютерын програм хангамжийг судалгааны зорилгоор бусад багуудад шилжүүлэх үйл явцыг ИТТ хариуцна.

17.2 ИТТ нь бүтээлийн зах зээлийн үнэ цэнийг хадгалахын тулд түгээхтэй холбогдсон гэрээг бичиж барааны тэмдэг эсвэл зохиогчийн эрх зэрэг оюуны өмчийн аль тохиромжтой хэлбэрээр хамгаалалт хийнэ.

17.3 Зохиогчид компьютерын програм хангамжийг нээлттэй эх сурвалжаар дамжуулан түгээхийг хүсвэл ИТТ-өөс зөвлөгөө авна. ИТТ нь тухайн бүтээлд захиалагч талын өмнө хүлээсэн үүрэг бий эсэх, мөн Паркын бусад оюуны өмчид сөрөг нөлөө үзүүлэхгүйгээр түгээж болох нээлттэй эх сурвалжийн талаар зөвлөгөө өгнө.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ТЕХНОЛОГИЙН АРИЛЖААНЫ ХӨГЖҮҮЛЭЛТ

18 дугаар зүйл. Арилжааны үзэл баримтлал

18.1 Нийтэд үйлчлэх үүргийнхээ хүрээнд судалгааны байгууллага, аж ахуйн нэгж, хувь хүний бүтээсэн оюуны өмч, шинэ мэдлэг, технологийг олон нийтэд түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн ажлыг Парк бодлогоор дэмжиж ажиллана.

18.2 Судалгааны үр дүнг оюуны өмчийн хэлбэрээр хамгаалан түүний лицензийн эрхийг баталгаажуулж, бараа үйлчилгээг хөгжүүлэн нийтийн хүртээл болгоход аж ахуйн нэгжийг шаардлагатай хөрөнгө оруулалт оруулахыг дэмжих бодлого баримтлана.

19 дүгээр зүйл. Зах зээлд нэвтрүүлэх - Арилжаалах

19.1 Технологид лиценз олгох, арилжаалах ажлыг ИТТ хариуцна. Тухайн технологийн зах зээлийг судлах, худалдан авагч этгээдийг тодорхойлох, лиценз худалдан авагчтай гэрээний талаар зөвшилцөх, зохих лиценз болон бусад гэрээний талаар хэлцэл хийх, гэрээ байгуулах, гэрээний биелэлтэд хяналт тавих, бүтээгч/зохиогч нарт энэ журмын дагуу роялти (шимтгэлийн орлого) ашгийг хуваарилах ажлыг ИТТ зохион байгуулна.

19.2 Тохиромжтой нөхцөлд Парк нь роялти ашгийн тодорхой хувьтай тэнцүү хэмжээгээр компанийн хөрөнгөнөөс (equity) хувь эзэмшиж болно.

19.3 Технологийн арилжааг хөгжүүлэхэд дараах зарчмыг баримтална. Үүнд:

19.3.1 Технологи дамжуулах, арилжих ажлыг амжилттай хэрэгжүүлэхэд бүтээгч/зохиогч нар ИТТ-д дэмжлэг туслалцаа үзүүлж, хамтран ажиллана.

19.3.2 Өндөр хөгжилтэй орны технологиос сонгон авч шаардлагатай байгууллага, аж ахуйн нэгжид дамжуулах, технологи нутагшуулахыг дэмжиж ажиллана.

19.3.3 Судалгааны байгууллага, аж ахуйн нэгж, хувь хүн, паркын мэргэжилтэн, гэрээт ажилтан нь өөрийн эзэмшдэг технологийг Паркаар дамжуулах, хөгжүүлэхийг хүсвэл Парктай гэрээ байгуулсны үндсэн дээр хамтран ажиллаж болно.

19.3.4 Паркын мэргэжилтэн, гэрээт ажилтан нь өөрсдийн хувьдаа эзэмшдэг технологийг арилжаалах арга замыг сонгоход ижил тэгш эрхтэй оролцоно. Тухайн технологи ямар нэг байдлаар Паркын захиалгат болон гэрээт ажлын хэсэг, эсвэл гэрээгээр хүлээсэн үүрэгт ажлынх нь үр дүн, эсвэл Паркын санхүүжилт, өмч хөрөнгийг мэдэгдэхүйцээр ашигласан зэрэгт хамааралгүй эсэхийг магадлан шалгана.

19.3.5 Энэ журмын 19.3.3-д дурдсан нөхцөлийн аль нэг нь илэрсэн тохиолдолд бүтээгч/зохиогч нар ИТТ-өөс тохирох лиценз олгохыг, эсвэл 4-Р БҮЛЭГТ заасанчлан Парк эзэмших эрхээсээ татгалзахыг хүсч болно.

19.3.6 Технологийн хөгжилд эерэг үр дүн гарсан ч ирээдүйн шинэ бүтээлтэй холбоотой ямар нэг амлалт, баталгааг Паркаас лиценз худалдан авагч этгээдэд гаргахгүй. Онцгой нөхцөлд маш нарийн тодорхойлсон тусгай заалтуудыг гэрээнд тусгаснаар дагавар (subordinate patents) патент болон лицензтэй програм хангамжийн хувилбар бүтээгдэхүүн зэрэгт ирээдүйн шинэ бүтээлийн баталгаа гаргаж болно.

20 дугаар зүйл. Патентыг арилжаалах

20.1 Оюуны өмчийн эрхийг нь хамгаалсан аж үйлдвэрийн өмчийг дамжуулах хүсэлтийг ИТТ хүлээн авсны дараа эрх нь хүчинтэй эсэх, мөн зах зээлд үр ашигтай нэвтрүүлэх боломжтой эсэхэд оюуны өмч, технологи дамжуулалт хариуцсан мэргэжилтэн үнэлгээ хийнэ.

20.2 Технологи Задлах Маягтыг ИТТ-д хүлээн авсны дараа тухайн шинэ бүтээлийг патентжуулах болон зах зээлд үр ашигтай нэвтрүүлэх боломжтой эсэх, мөн захиалагчдын өмнө гэрээгээр ямар үүрэг хүлээсэн зэрэгт технологид лиценз олголт хариуцсан ажилтан үнэлгээ хийнэ.

20.3 Үнэлгээний үр дүнд шаардлага хангасан технологийг дамжуулах лицензийн гэрээний, арилжаалах бол эрх шилжүүлэх гэрээний нөхцөлийг тус тус тохирч гэрээ байгуулна.

20.4 ИТТ тухайн технологитой холбоотой хийгдэх шүүлт, зах зээлийн судалгааны ажилд бүтээгч/зохиогчдоос нэг хүнийг оролцуулах хүсэлт гаргаж болно.

20.5 Хэрэв шинэ бүтээл ямар нэг захиалгат төслийн үр дүн байвал ИТТ нь мэдүүлэг бүрдүүлэн патентын эрхийг бүртгүүлэхээр өгөхийн сацуу тохирох лицензийн гэрээ хэлцлийг тус захиалгат ажлын гэрээнд нийцүүлэн эхлүүлнэ.

20.6 ИТТ нь төслийн гэрээ бүрт патентын онцгой нөхцөлийн талаар зөвлөгөө өгч болно.

21 дүгээр зүйл. Зохиогчийн эрхтэй бүтээлийг арилжаалах

21.1 Энэ журамд заасан онцгой нөхцөлүүдээс бусад тохиолдолд Паркын эзэмшлийн зохиогчийн эрхээр хамгаалагдах боломжтой ажилд лиценз олголтыг ИТТ хариуцна.

21.2 Парк эрхийг нь эзэмшдэггүй зохиогчийн эрхээр хамгаалах боломжтой ажлыг зохиогч нь эрхээ шилжүүлэхийг зөвшөөрч, Технологи Задлах Маягтыг бөглөж өгснөөр лиценз олгох ажлыг ИТТ хариуцаж болно.

21.3 Компьютерын програм хангамжийг зах зээлд нэвтрүүлэхэд дараах зарчмыг баримтална. Үүнд:

21.3.1 Парк эрхийг нь эзэмших компьютерын програм хангамжийн бүтээлд патентын эсвэл зохиогчийн эрхийн хамгаалалт хийж болно.

21.3.2 Програм хангамж ИТТ-өөр дамжиж патент болон зохиогчийн эрхийн лицензийн олон хэлбэрээр зах зээлд нэвтрэх боломжтой байх ёстой.

21.3.3 Парк нь зохиогчтой байгуулсан гэрээний дагуу роялти ашгаас хүртэх хувиа тохиролцож болно.

21.3.4 Бүтээсэн програм хангамж нь ИТТ-өөр дамжиж лицензийн гэрээгээр гуравдагч этгээдэд очсон байх тохиолдолд зохиогч нь судалгааны зорилгоор үнэгүй лиценз олгох хүсэлтэй бол заавал ИТТ-тэй хамтарч энэ ажлыг зохион байгуулна.

21.4 Паркын үйл ажиллагаанд зориулсан буюу Паркын нэгжийн хэрэгцээнд зориулан захиалгаар бүтээсэн аливаа дүрс бичлэгийн бүтээлийг зохиогчийн эрхээр хамгаалж, түүнийг эзэмших болон арилжаалах эрхийг нь тухайн тохиолдол болгонд хийсэн гэрээний дагуу шийднэ.

22 дугаар зүйл. Барааны тэмдгийг арилжаалах

22.1 Паркын эзэмшдэг бараа болон үйлчилгээний тэмдэгт лиценз олгохыг ИТТ хариуцна.

23 дугаар зүйл. Парк бүтээгч/зохиогчид нь лиценз олгох

23.1 Паркын мэргэжилтэн, гэрээт ажилтан - бүтээгч/зохиогчид нь өөрсдийн бүтээсэн Паркын эзэмшдэг шинэ бүтээлд, эсвэл зохиогчийн эрхтэй материалд арилжааны зорилгоор лиценз авах хүсэлт гаргаж болно.

23.2 Бүтээгч/зохиогч нь ямар нэг давуу эрх эдлэхгүй ба Паркын гуравдагч этгээдтэй харилцдаг журмын дагуу ашиг сонирхолын зөрчилдөөн үүсгэлгүй ижил тэгш эрх эдэлнэ.

23.3 Лицензийн гэрээг бүтээгч/зохиогчтой нь байгуулахдаа тухайн технологийг хөгжүүлж түгээн дэлгэрүүлэх төлөвлөгөө болон оногдох роялти төлбөрийн талаар тусгана. Гэрээний хэлцэл, тохиролцоо нь ашиг сонирхолын зөрчлөөс сэргийлэхдээ энэ журмын 26 дугаар зүйлд заасан зарчмыг баримтална.

23.4 Олон зохиогчтой, хөгжүүлэхэд урт хугацаа зарцуулсан чухал төслүүдийн хувьд зохиогчийн эрхийг нь хамгаалсан материалыг хамгийн үр бүтээлтэйгээр түгээн дэлгэрүүлэх төлөвлөгөөг ИТТ-тэй зөвлөж, тусгай хэлцэл хийх шаардлагатай.

23.5 Энэ журамд заасны дагуу бүтээгч/зохиогчийн гаргасан хүсэлтэд Парк нь 90 хоногт багтааж хариу өгнө. Зохих үнэлгээ хийх боломжгүй, бүрэн боловсроогүй програм хангамж зэрэг ажлуудын хувьд зохиогчийн хүсэлтийн хариуг өгөхийн өмнө Парк нэмэлт боловсруулалт хийхийг шаардах эрхтэй.

24 дүгээр зүйл. Роялти ашиг хуваарилах

24.1 Парк хүлээн авсан нийт роялти ашгийг гэрээнд өөрөөр заагаагүй бол санхүүгийн жилийн эцсээр энэ журмын 24.2, 24.3-д заасны дагуу хуваарилж тараана.

24.2 Парк хувь эзэмшдэг технологийг дамжуулснаас олох роялти орлогыг дараах томьёоллын дагуу хуваарилна. Үүнд:

24.2.1 Бүтээгч/зохиогчийн хувийг бодохдоо Тохиолдол (case) тус бүрт гарч ирэх зохиогчийн роялти ашгийг дараах аргачлалаар тооцож, хуваарилна.

24.2.1.1 Нийт Роялти Орлогоос шууд зардлыг хасна.

24.2.1.2 Үлдэгдэл Роялти Ашгийн 40 хувийг (цаашид "Бүтээгчийн хувь" гэх) бүтээгч/зохиогч нарт олгоно.

24.2.1.3 Бүтээгчийн хувийг олгох хуваарилалт нь бүтээгч/зохиогчдын оролцсон ажлын гэрээнд зөвшөөрсөн нөхцөлтэй ижил байх ёстой. Бүтээгчийн хувийг хүн бүрт харилцан адилгүй хуваарилахыг зөвшөөрч бүх бүтээгч/зохиогчид гарын үсэг зуран бичгээр ирүүлээгүй тохиолдолд Үлдэгдэл Роялти Ашгаас олгох бүтээгчийн хувийг бүтээгч нарт ижил тэнцүү хуваарилна.

24.2.2 Паркын Роялти хувь бодохдоо дараах аргачлалаар тооцно.

24.2.2.1 Үлдэгдэл Роялти Ашгийн 30 хувийг Паркд хуваарилна.

24.2.2.2 Паркад ногдсон Үлдэгдэл Роялти Ашгийн 50 хувийг инноваци, гарааны бизнес, технологийн судалгаа хөгжүүлэлт, хүний нөөцийг бэлтгэх, антрепренёрыг дэмжихэд зориулагдах санд хуримтлуулна.

24.2.3 ИТТ буюу технологи дамжуулах ажлыг зохион байгуулж, гүйцэтгэсэн баг, хувь хүнд Роялти хувь бодохдоо дараах аргачлалаар тооцно.

24.2.3.1 Үлдэгдэл Роялти Ашгийн 30 хувийг Паркын технологи дамжуулах ажлыг гүйцэтгэсэн баг, хувь хүнд хуваарилна.

24.2.3.2 Багийн хувийг олгох хуваарилалт нь багийн гишүүдийн оролцсон ажлын гэрээнд зөвшөөрсөн нөхцөлтэй ижил байх ёстой. Багийн хувийг хүн бүрт харилцан адилгүй хуваарилахыг зөвшөөрч бүх гишүүд гарын үсэг зуран бичгээр ирүүлээгүй тохиолдолд Үлдэгдэл Роялти Ашгаас багт олгох хувийг гишүүдэд ижил тэнцүү хуваарилна.

24.3 Парк хувь эзэмшдэггүй буюу судалгааны байгууллага, аж ахуйн нэгж, хувь хүний эрхийг нь эзэмшдэг технологийг дамжуулснаас олох роялти орлогыг дараах томьёоллын дагуу хуваарилна. Үүнд:

24.3.1 Эрх эзэмшигчийн хувийг бодохдоо Тохиолдол (case) тус бүрт гарч ирэх зохиогчийн роялти ашгийг дараах аргачлалаар тооцож, хуваарилна.

24.3.1.1 Нийт Роялти Орлогоос шууд зардлыг хасна.

24.3.1.2 Үлдэгдэл Роялти Ашгаас хэдэн хувийг Парк болон эрх эзэмшигчид хуваарилахыг тохиролцсон гэрээний дагуу хувийг олгоно.

24.3.2 Парк нь эрх эзэмшигчтэй хийсэн гэрээний дагуу ногдсон Үлдэгдэл Роялти Ашгийн хувийг хуваарилахдаа дараах аргачлалаар тооцно.

24.3.2.1 Ногдсон Үлдэгдэл Роялти Ашгийн 60 хувийг Паркд хуваарилна.

24.3.2.2 Парк нь ногдсон Үлдэгдэл Роялти Ашгийн 60 хувийн 30 хувийг нь инноваци, гарааны бизнес, технологийн судалгаа хөгжүүлэлт, хүний нөөцийг бэлтгэх, антрепренёрыг дэмжихэд зориулагдах санд хуримтлуулна.

24.3.3 ИТТ буюу технологи дамжуулах ажлыг зохион байгуулж, гүйцэтгэсэн баг, хувь хүнд Роялти хувь бодохдоо дараах аргачлалаар тооцно.

24.3.3.1 Ногдсон Үлдэгдэл Роялти Ашгийн 40 хувийг Паркын технологи дамжуулах ажлыг гүйцэтгэсэн баг, хувь хүнд хуваарилна.

24.3.3.2 Багийн хувийг олгох хуваарилалт нь багийн гишүүдийн оролцсон ажлын гэрээнд зөвшөөрсөн нөхцөлтэй ижил байх ёстой. Багийн хувийг хүн бүрт харилцан адилгүй хуваарилахыг зөвшөөрч бүх гишүүд гарын үсэг зуран бичгээр ирүүлээгүй тохиолдолд Үлдэгдэл Роялти Ашгаас багт олгох хувийг гишүүдэд ижил тэнцүү хуваж хуваарилна.

24.4 Хэрэв хэн нэг бүтээгч/зохиогч нь хамтын ажлын гэрээг зөрчиж Паркын нэр хүнд, өмч хөрөнгө, эд материалд хохирол учруулсан нь илэрч, шалгалтаар нотлогдвол тус бүтээгч/зохиогчид тухайн хамтын ажлын гэрээний үр дүнд бий болсон шинэ бүтээлийн роялти ашгийн хэсгийг нь эсвэл бүгдийг нь олгохоос Паркын Ёс зүйн хороо, Оюуны өмчийн асуудал хариуцсан нэгжийн санал дүгнэлтэд үндэслэн Ерөнхий захирал татгалзаж болно.

25 дугаар зүйл. Роялти – онцгой тохиолдолд хуваарилах

25.1 Технологи нь нэгжийн хэрэгжүүлсэн төслийн үр дүнд, эсвэл бүтээгч/зохиогч нь хялбар тодорхойлогдох боломжгүй нөхцөлд бий болсон байх тохиолдолд хувь хүнд ногдох роялти ашгийн хуваарилалт түгээмэл бус байх онцгой тохиолдол гарч болно. Энэ тохиолдолд дараах зарчмыг баримтална. Үүнд:

25.1.1 ИТТ-ийн дарга онцгой тохиолдол бий болсон нөхцөл байдлыг төслийн ерөнхий удирдагч (захиалгат төслийн ажил биш тохиолдолд нэгжийн удирдлага)-тай зөвлөсний үндсэн дээр тогтооно.

25.1.2 Роялти ашиг нь хувь хүнд ногдохоргүй байх тохиолдолд хуваарилалтыг Паркын Ерөнхий захирал баталсны дагуу хуваарилна.

25.2 Парк нь оюуны өмчөө ашиглуулсан роялти орлогын оронд эсвэл роялти орлогын тодорхой хэсгийн оронд компаниас хувь эзэмшиж болно. Паркын эзэмшдэггүй технологийг дамжуулсны роялти орлогын оронд эсвэл роялти орлогын тодорхой хэсгийн оронд компаниас хувь эзэмших тухай асуудлыг эрх эзэмшигчтэй байгуулсан гэрээний дагуу шийдвэрлэнэ.

25.3 Бүтээгч/зохиогч нь компаниас хувь эзэмшихээр болсон тохиолдолд Парк-д ногдох хувиас хуваалцахгүй.

26 дугаар зүйл. Ашиг сонирхлын зөрчилдөөнөөс сэргийлэх тухай

26.1 Парк өөрийн эзэмшдэг технологио эзэмших эрхээсээ татгалзаж бүтээгч/зохиогчид нь шилжүүлэх, эсвэл лиценз олгохоос өмнө дараах шинжийн аль нэг нь ажиглагдвал ашиг сонирхлын зөрчилдөөн үүссэн гэж үзнэ. Үүнд:

26.1.1 Бүтээгч/зохиогчийн Парк дахь ажил үүргээс цаг хугацаа, ажлын чиг үүргийн хувьд хэтэрсэн байх, зохисгүй нөлөө гарах;

26.1.2 Парк үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд хүлээсэн үүрэгт сөрөг нөлөө гарах;

26.1.3 Монгол Улсын хууль тогтоомж болон Паркын дүрэм, журмуудад заасан ашиг сонирхлын зөрчилдөөн;

26.2 Паркаас гарах гарааны компаниудын хувьд ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэхийн тулд дараах зарчмыг баримтална. Үүнд:

26.2.1 Хэрэв бүтээгч/зохиогч нь шинэ бүтээлийн лиценз эзэмшигч компани, аж ахуйн нэгж (ААН)-ийн үнэт цаас, эсвэл хувь, эсвэл үүсгэн байгуулагчийн хувьцаа ба/эсвэл опцион (option) эзэмшдэг, эсвэл удахгүй эзэмших гэж байгаа бол Ерөнхий захирал шийдвэр гаргасны үндсэн дээр Парк нь роялти орлогын оронд хувь эзэмшиж болно.

26.2.2 Хэрэв бүтээгч/зохиогч компани үүсгэн байгуулагдаж дуусаны дараа тус компаниас хувь эзэмшихийн зэрэгцээ Паркад ажилласан хэвээр үлдэхээр болсон бол тухайн бүтээгч/зохиогч Зөрчилдөөнөөс зайлсхийх баримт (Хавсралт А3-р маягт)-д гарын үсэг зурсан байх шаардлагатай.

26.3 Оюуны өмч, технологи дамжуулалт, инновацийн асуудал хариуцсан мэргэжилтэн болон технологи дамжуулах үйл явцад албан үүргийн дагуу оролцох мэргэжилтэн нь ашиг сонирхлын аливаа зөрчилдөөн гарахаас сэргийлэхийн тулд дараах зарчмыг баримтална. Үүнд:

26.3.1 ИТТ-ийн ажилтан бүр Паркын дамжуулсан оюуны өмчийг ашиглах лицензтэй, хувьцаа гаргаагүй компанид ямар нэг байдлаар хувийн хөрөнгө оруулалт хийхгүй байх;

26.3.2 Хэрэв ажилтан вэнч хөрөнгө оруулалтын хамтрагч бол, тэр ажилтан тухайн вэнч сангаас хөрөнгө оруулалт хийсэн ямар ч компаниас Паркын дамжуулж байгаа оюуны өмчид лиценз авах гэрээ хэлцэлд оролцохыг хориглоно.

26.3.3 Компани, ААН нь Паркын дамжуулах оюуны өмчийг гэрээний дагуу ашиглах, эзэмших тухай мэдээлэл, мэдлэг нь ямар нэг байдлаар гадагш алдагдаж, тухайн оролцогч компани, ААН-ийн хувь, хувьцааны үнэнд нөлөөлж болохуйц байдал гаргахгүй байх талаар тусгай үүргийг ИТТ-ийн ажилтан хүлээнэ.

26.3.4 Олж авсан мэдээллээ хувийн, гэр бүл, найз нөхөд, бизнесийн түнш нарт давуу байдал олгож хөрөнгө оруулалт хийх зорилгод ашиглахыг хатуу хориглоно.

ТАВДУГААР БҮЛЭГ. МЭРГЭЖИЛТЭН БА ГЭРЭЭТ АЖИЛТНЫ ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА

27 дугаар зүйл. Үүрэг хариуцлагын тухай

27.1 Энэхүү журамд заасан технологийг эзэмших зарчмыг Паркад ажил эрхэлж буй, эсвэл хамтарсан төсөл, захиалгат ажилд оролцож буй, эсвэл Паркын санхүүжилт ба өмч хөрөнгийг ашиглаж буй бүх этгээд хүлээн зөвшөөрч, журмын 28 дугаар зүйл дэх Шинэ Бүтээл ба Үнэт Мэдээллийн Нууцын Гэрээнд гарын үсэг зурна.

24.3.3 ИТТ буюу технологи дамжуулах ажлыг зохион байгуулж, гүйцэтгэсэн баг, хувь хүнд Роялти хувь бодохдоо дараах аргачлалаар тооцно.

24.3.3.1 Ногдсон Үлдэгдэл Роялти Ашгийн 40 хувийг Паркын технологи дамжуулах ажлыг гүйцэтгэсэн баг, хувь хүнд хуваарилна.

24.3.3.2 Багийн хувийг олгох хуваарилалт нь багийн гишүүдийн оролцсон ажлын гэрээнд зөвшөөрсөн нөхцөлтэй ижил байх ёстой. Багийн хувийг хүн бүрт харилцан адилгүй хуваарилахыг зөвшөөрч бүх гишүүд гарын үсэг зуран бичгээр ирүүлээгүй тохиолдолд Үлдэгдэл Роялти Ашгаас багт олгох хувийг гишүүдэд ижил тэнцүү хуваарилна.

24.4 Хэрэв хэн нэг бүтээгч/зохиогч нь хамтын ажлын гэрээг зөрчиж Паркын нэр хүнд, өмч хөрөнгө, эд материалд хохирол учруулсан нь илэрч, шалгалтаар нотлогдвол тус бүтээгч/зохиогчид тухайн хамтын ажлын гэрээний үр дүнд бий болсон шинэ бүтээлийн роялти ашгийн хэсгийг нь эсвэл бүгдийг нь олгохоос Паркын Ёс зүйн хороо, Оюуны өмчийн асуудал хариуцсан нэгжийн санал дүгнэлтэд үндэслэн Ерөнхий захирал татгалзаж болно.

25 дугаар зүйл. Роялти – онцгой тохиолдолд хуваарилах

25.1 Технологи нь нэгжийн хэрэгжүүлсэн төслийн үр дүнд, эсвэл бүтээгч/зохиогч нь хялбар тодорхойлогдох боломжгүй нөхцөлд бий болсон байх тохиолдолд хувь хүнд ногдох роялти ашгийн хуваарилалт түгээмэл бус байх онцгой тохиолдол гарч болно. Энэ тохиолдолд дараах зарчмыг баримтална. Үүнд:

25.1.1 ИТТ-ийн дарга онцгой тохиолдол бий болсон нөхцөл байдлыг төслийн ерөнхий удирдагч (захиалгат төслийн ажил биш тохиолдолд нэгжийн удирдлага)-тай зөвлөсний үндсэн дээр тогтооно.

25.1.2 Роялти ашиг нь хувь хүнд ногдохоргүй байх тохиолдолд хуваарилалтыг Паркын Ерөнхий захирал баталсны дагуу хуваарилна.

25.2 Парк нь оюуны өмчөө ашиглуулсан роялти орлогын оронд эсвэл роялти орлогын тодорхой хэсгийн оронд компаниас хувь эзэмшиж болно. Паркын эзэмшдэггүй технологийг дамжуулсны роялти орлогын оронд эсвэл роялти орлогын тодорхой хэсгийн оронд компаниас хувь эзэмших тухай асуудлыг эрх эзэмшигчтэй байгуулсан гэрээний дагуу шийдвэрлэнэ.

25.3 Бүтээгч/зохиогч нь компаниас хувь эзэмшихээр болсон тохиолдолд Парк-д ногдох хувиас хуваалцахгүй.

26 дугаар зүйл. Ашиг сонирхлын зөрчилдөөнөөс сэргийлэх тухай

26.1 Парк өөрийн эзэмшдэг технологио эзэмших эрхээсээ татгалзаж бүтээгч/зохиогчид нь шилжүүлэх, эсвэл лиценз олгохоос өмнө дараах шинжийн аль нэг нь ажиглагдвал ашиг сонирхлын зөрчилдөөн үүссэн гэж үзнэ. Үүнд:

26.1.1 Бүтээгч/зохиогчийн Парк дахь ажил үүргээс цаг хугацаа, ажлын чиг үүргийн хувьд хэтэрсэн байх, зохисгүй нөлөө гарах;

26.1.2 Парк үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд хүлээсэн үүрэгт сөрөг нөлөө гарах;

28 дугаар зүйл. Хувь хүний шинэ бүтээл ба үнэт мэдээллийн нууцын гэрээ

28.1 Энэхүү нууцлалын гэрээнд дор дурдсан этгээдүүд дараах нөхцөлд гарын үсэг зурна. Үүнд:

28.1.1 Хамтарсан төсөл, захиалгат ажил эсвэл Паркын санхүүжүүлсэн төслөөс санхүүгийн дэмжлэг авсан этгээд Шинэ Бүтээл ба Үнэт Мэдээллийн Нууцын Гэрээ (ШБҮМНГ: Хавсралт А4 маягт)-нд гарын үсэг зурах ёстой.

28.1.2 Захиалгат эсвэл Паркаас санхүүжсэн ажлын үр дүнд шинэ бүтээлийг бүтээсэн/хөгжүүлсэн, бодит хэрэглээнд нэвтрүүлсэн, эсвэл технологийг хөгжүүлсэн этгээд;

28.1.3 Паркын санхүүжилт, өмч хөрөнгийг мэдэгдэхүйц хэмжээгээр ашигласан этгээд цалин буюу бусад хэлбэрийн дэмжлэгийг авсан эсэхээс үл хамааран;

28.1.4 Паркын бүх гэрээт ажилтан (Хавсралт А5 маягтыг үзнэ үү.);

28.2 Паркын нэгж болгон захиалгат ажил, хамтарсан төсөлд оролцсон, эсвэл оролцох магадлалтай, эсвэл тухайн нэгжээр дамжуулан Паркын мэдэгдэхүйц өмч хөрөнгө, санхүүжилтийг авч ашиглах боломжтой мэргэжилтэн, гэрээт ажилтан бүрийг Шинэ Бүтээл ба Үнэт Мэдээллийн Нууцын Гэрээнд гарын үсэг зуруулах үүрэгтэй.

28.3 Шинэ Бүтээл ба Үнэт Мэдээллийн Нууцын Гэрээг гурван хувь үйлдэж гарын үсэг зуран хувь хүн, Паркын нэгж, ИТТ тус бүр нэг хувийг хадгална.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

29 дүгээр зүйл. Ерөнхий захирал

29.1 Паркын Ерөнхий захирал нь энэхүү журамтай холбоотой ямар нэгэн маргаантай асуудлыг эцэслэн шийдвэрлэнэ.

29.2 Зарим онцгой нөхцөл байдал үүссэн тохиолдолд Ерөнхий захирал энэ журамд зааснаас өөр шийдвэрийг Даргын зөвлөлөөр хэлэлцүүлж, зөвшилцсөний үндсэн дээр гаргаж болно.

30 дугаар зүйл. Инноваци, технологийн төв

30.1 Инноваци, технологийн төв (ИТТ) нь Парк ба захиалагч, гэрээлэгч байгууллага хоорондын захиалгат ажил, хамтарсан төслийн ажлын гэрээг байгуулах үйл явцыг удирдах бөгөөд захиалагчийн санхүүжүүлсэн төслийн үр дүнд бүтсэн/хөгжсөн технологийг тухайн захиалагч эзэмших давуу эрхийг нь баталгаажуулж өгнө.

30.2 Ойлгомжгүй нөхцөл байдал үүссэн эсхүл давуу зэргийн хувьд зөрчилдөөн гарсан тохиолдолд Ерөнхий захиралд уламжилж шийдвэрлүүлнэ.

30.3 Судалгааны байгууллага, аж ахуйн нэгж, парк, хувь хүний бүтээсэн, хөгжүүлсэн технологийг нийтийн тусын тул ашиглуулахаар дамжуулахад үйлчлэх үүрэгтэй.